

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/61/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас:323266 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Лхагвацэнд Утас:323266 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn Аудитор: С.Билгүтэй Утас:323266 Цахим хаяг: bilguteis@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ПҮРЭВЖАРГАЛ ТАНАА

2026.03.16 № 728
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг Дүгнэлтийн Үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 161,594.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг ба өргөн тархсан байна. Тухайлбал:

- Тайлант онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн 6 багцын 2,822,442.1 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэхдээ “Дуусаагүй үйлдвэрлэл” дансанд дээрх хөрөнгөтэй холбоотой 43,659.4 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг үндсэн хөрөнгийн өртөлт шилжүүлэн бүртгээгүй, гүйцэтгэгчээс ирүүлсэн үнийн дүнгээр орлогод авч бүртгэсэн;
- Санхүүгийн тайланд нийт 83,927.6 сая төгрөгийн авлага, 33,052.4 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж 338.5 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан;

- Богдхан төмөр зам төсөлтэй холбоотой 21,132.9 сая төгрөгийн зардал дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй, төслийн үр ашиг, эдийн засгийн өгөөжийг тодорхойлох боломжгүй, цаашид хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлүүлээгүй;
- Ашиглах боломжгүй болсон, гэмтэж хоцрогдолд орсон 337.1 сая төгрөгийн бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолж, өртгийг бодитой тогтоож бүртгэлд тусгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй;
- Насжилт өндөртэй 810.5 сая төгрөгийн авлагад үнэ цэнийн бууралт тооцож, бодит үнэ цэнээр бүртгэх, ангилах, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй;
- Өмнөх оны аудитаар өгсөн олон улсын аудитын зөвлөх үйлчилгээний тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороогоор хэлэлцүүлж, зохих дүгнэлт шийдвэрийг гаргуулаагүй.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 12 дугаар зүйлийн 12.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.26 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, 72 дугаар зүйлийн 72.5, 73 дугаар зүйлийн 73.4 дахь заалтуудтай нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1.15, 16.11, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын 13.24-ыг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 103 дугаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг “Монголын төмөр зам” ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авах, тус төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцоо нийлж, үндсэн хөрөнгөд бүртгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг даалгасны дагуу “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Монголын төмөр зам” ТӨХК нар 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн ТҮГ/2025/11, ТҮГ-2025/07 дугаартай 1,400.0 сая төгрөгийн түрээсийн төлбөр бүхий “Хөрөнгө түрээслэх гэрээ”-г байгуулж, компанийн өөрийн хөрөнгөөр олж авсан 240,158.4 сая төгрөгийн хөрөнгө, төслийн хүрээнд бий болсон 2,795,745.4 сая төгрөгийн 5 багц хөрөнгийг түрээслүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон баталжээ. Төрийн худалдан авах ажиллагааны даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/1/1752 дугаар бичгээр “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл”-ийг “Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп” ХХК-д хүргүүлж, 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр барилгын ажил гүйцэтгэх гэрээг “Тавантолгой төмөр зам” ХХК-тай, 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр “Эрдэнэс тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК нартай 3 талт санхүүжилтийн гэрээг тус тус байгуулж, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслөөс 254,657.9 сая төгрөгийн санхүүжилт авч, бүтээн байгуулалтын ажил эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай”, 24 дүгээр “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” тогтоолуудын хавсралтад тусгасны дагуу Засгийн газрын 2021 оны 230/254 дүгээр тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл, барилгын ажлын зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгож, 2021 оны 08 дугаар сарын 23-ний өдрөөс эхлэн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн боловч Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 62 дугаар тэмдэглэлээр төслийг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ээр хариуцуулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж, ажил зогсоох мэдэгдлийг хүргүүлсэн байна. Дээрх шийдвэрийн хүрээнд Монголын Үндэсний худалдаа, Аж үйлдвэрийн Танхимаас 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр олгосон “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл”-ийн гэрчилгээг үндэслэн ажил зогссон байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн эзэмшиж буй 34 хувийн хувьцааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д шилжүүлж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих төсөл, Тавантолгой-Гашуунсухайт болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төсөлд олгосон санхүүжилтийг төрийн эзэмшлийн ногдол ашигт тооцож, шилжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасан бөгөөд өмчийн 100 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК эзэмшиж, хувьцаа захиран зарцуулах эрх зөвхөн Монгол Улсын Засгийн газарт хадгалагдахаар тусгасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	39,434,750,644.07	8,803,859,143.42
1.1.02	Дансны авлага	17,146,580,280.04	99,723,854,886.55
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	84,718,246,780.96	97,886,984,645.61
1.1.04	Бусад авлага	122,454,639,359.80	104,682,765,020.95
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	73,925,649,809.06	91,584,283,529.96
1.1.06	Бараа материал	4,196,585,662.62	6,617,859,435.73
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,515,035,254,968.33	176,170,848,763.99
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,856,911,707,504.88	585,470,455,426.21
1.2.01	Үндсэн хөрөнгө	140,560,328,715.93	2,950,906,927,817.91
1.2.02	Биет бус хөрөнгө	230,566,551,659.77	236,333,787,729.96
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,293,590,464,907.63	1,009,217,704,708.35
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,664,717,345,283.33	4,196,458,420,256.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,521,629,052,788.21	4,781,928,875,682.44
2.1.1.01	Дансны өглөг	445,051,557,379.51	446,779,035,497.29
2.1.1.02	Цалингийн өглөг	600,167.86	-
2.1.1.03	Татварын өр	5,743,115,220.11	2,874,387,773.64
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	210,544,859.43
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	21,858,131,589.91	18,759,199,419.88
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	24,181,691,170.65	86,317,661,399.33
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	496,835,095,528.04	554,940,828,949.57
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	262,318,635,727.02
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	1,336,052,948.25	1,032,415,607.20
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,336,052,948.25	263,351,051,334.22
2.2	Өр төлбөрийн нийт дүн	498,171,148,476.29	818,291,880,283.79
2.3.01	Өмч: - төрийн	2,040,479,750,000.00	2,040,479,750,000.00
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,937,106,372,907.65	1,939,236,183,907.65
2.3.09	Хуримтлагдсан ашиг	45,871,781,404.27	(16,078,938,509.00)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(61,950,719,913.27)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	45,871,781,404.27	45,871,781,404.27
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,023,457,904,311.92	3,963,636,995,398.65
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,521,629,052,788.21	4,781,928,875,682.44

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	95,144,528,068.06	16,106,431,621.15
02	Борлуулалтын өртөг	67,055,989,706.45	37,304,746,498.00
03	Нийт ашиг(алдагдал)	28,088,538,361.61	(21,198,314,876.85)
04	Түрээсийн орлого	22,117,899,012.70	19,240,383,610.57
05	Хүүний орлого	8,896,839,704.37	4,458,810,693.05
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	1,375,086,070.78	843,758,154.87
08.1	Орлогын дүн	32,389,824,787.85	24,542,952,458.49
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	10,293,769,582.41	64,753,433,121.21
11	Санхүүгийн зардал	-	334,608,674.10
12	Бусад зардал	-	-
12.1	Зардлын дүн	10,293,769,582.41	65,088,041,795.31
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	(15,289,250.00)	(87,747,072.73)
17.1	Олз, гарзын дүн	(15,289,250.00)	(87,747,072.73)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	50,169,304,317.05	(61,831,151,286.40)
19	Орлогын татварын зардал	10,311,600,581.58	119,568,626.87
20	Татварын дараах ашиг (алдагдал)	39,857,703,735.47	(61,950,719,913.27)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	39,857,703,735.47	(61,950,719,913.27)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	2,040,479,750,000.00	1,858,936,268,852.87	4,677,186,857.34	3,904,093,205,710.21
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	1,336,890,811.46	1,336,890,811.46
03	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	39,857,703,735.47	39,857,703,735.47
05	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	78,170,104,054.78	-	78,170,104,054.78
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	2,040,479,750,000.00	1,937,106,372,907.65	45,871,781,404.27	4,023,457,904,311.92
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(61,950,719,913.27)	(61,950,719,913.27)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	2,129,811,000.00	-	2,129,811,000.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	2,040,479,750,000.00	1,939,236,183,907.65	(16,078,938,509.00)	3,963,636,995,398.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	-	-
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	166,917,111,463.61	363,076,597,778.40
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	100,314,974,473.23	18,982,220,060.14
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	451,889.92
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	12,358,662.00	54,307,521.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	42,505,576,979.22	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	24,084,201,349.16	344,039,618,307.34
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	141,382,627,293.09	294,740,131,110.46
1.2.1	Ажиллагчдад төлсөн	31,977,953,685.09	19,260,868,224.82
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,030,473,354.22	5,075,660,759.45
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	5,738,086,040.36	2,335,451,640.21
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	3,310,189,200.89	1,547,620,612.54
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,305,117,489.29	3,068,193,642.79
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	987,085,671.23
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	9,014,907,534.69	7,663,093,478.65
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	258,653,727.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	71,747,246,261.55	254,802,157,080.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,534,484,170.52	68,336,466,667.94
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	931,082,534.34	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	931,082,534.34	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,216,573,090.00	77,842,936,811.33
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,216,573,090.00	472,434,053.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	77,370,410,758.33

2.2.6	Бусад	-	92,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,285,490,555.66)	(77,842,936,811.33)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,212,365,601.48	(37,325,731,589.04)
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	6,212,365,601.48	(37,325,731,589.04)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	61,006,780,104.52	(16,201,310,231.78)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	61,006,780,104.52	(16,201,310,231.78)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(54,794,414,503.04)	(21,124,421,357.26)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(30,545,420,888.18)	(30,630,891,500.65)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	69,980,171,532.25	39,434,750,644.07
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,434,750,644.07	8,803,859,143.42

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 он			
			төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Тээврийн үйл ажиллагаа /мян.тн/	4,156.8	6,860.0	683.8	6,176.2	10
2	Нийт орлого, санхүүжилт	127,534,352,855.9	294,259,144,758.4	295,307,350,036.2	(1,048,205,277.8)	100
2.1	Нийт орлого	127,534,352,855.9	39,601,178,801.8	40,649,384,079.6	(1,048,205,277.8)	103
2.1.1	Цэвэр борлуулалт	95,144,528,068.1	15,404,120,238.6	16,106,431,621.2	(702,311,382.5)	105
2.1.2	Түрээсийн орлого	22,117,899,012.7	14,068,634,874.1	19,240,383,610.6	(5,171,748,736.5)	137
2.1.3	Бусад орлого	10,271,925,775.2	10,128,423,689.1	5,302,568,847.9	4,825,854,841.2	52
2.2	Төслийн санхүүжилт	-	254,657,965,956.6	254,657,965,956.6	-	100
2.2.1	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төсөл	-	254,657,965,956.6	254,657,965,956.6	-	100
3	Нийт зардал	77,349,854,948.9	112,686,969,998.4	102,392,788,293.3	10,294,181,705.1	91
3.1	Борлуулалтын өртөг	67,056,085,366.5	41,863,319,205.7	37,304,746,498.0	4,558,572,707.7	89
3.2	Ерөнхий удирдлагын зардал /Санхүүгийн зардал орсон/	10,293,769,582.4	70,823,650,792.7	65,088,041,795.3	5,735,608,997.4	92
4	Хяналт хэрэгжүүлэх зардал	4,649,310,300.0	14,308,221,918.4	3,621,071,288.1	10,687,150,630.3	25
6	Бусад ашиг алдагдал	15,289,250.0	-	87,747,072.7	(87,747,072.7)	-
7	Хүү, татварын өмнөх ашиг	50,169,208,657.0	(73,085,791,196.6)	(61,831,151,286.4)	(11,254,639,910.2)	85
8	ОАТ-ын зардал	10,311,600,581.6	-	119,568,626.9	(119,568,626.9)	-
9	Цэвэр ашиг/алдагдал	39,857,608,075.5	(73,085,791,196.6)	(61,950,719,913.3)	(11,135,071,283.3)	85
10	Хөрөнгө оруулалт	15,209,830,028.6	268,547,233,452.9	246,515,757,088.6	22,031,476,364.3	92
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.61	2.7	2.5	0.2	93
12	Авлага	224,263,210,292.2	885,530,000,000.0	302,293,604,553.1	583,236,395,446.9	34
13	Өглөг	451,564,480,523.4	530,283,155,000.9	818,291,880,283.8	(288,008,725,282.9)	154
14	Дундаж ажиллагсдын тоо	730	479	445	33.8	93

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Тавантолгой төмөр зам” ХХК нь эрхэм зорилгоо “төмөр замын үйл ажиллагаа, төслийн удирдлагыг үндэсний эрх ашигт нийцсэн, чанар аюулгүй байдлыг эрхэмлэсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартаар хэрэгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тус компанийн дүрэмд зааснаар үйл ажиллагааны үндсэн чиглэлийг “төмөр замын суурь бүтэц барих, төмөр замын суурь бүтэц ашиглах, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн засварлах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх” гэж тодорхойлжээ.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” статустай, өмчийн 100 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК эзэмшиж, хувьцаа захиран зарцуулах эрх зөвхөн Монгол Улсын Засгийн газарт хадгалагдахаар тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн эзэмшиж буй 34 хувийн хувьцааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д шилжүүлж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих төсөл, Тавантолгой-Гашуунсухайт болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төсөлд олгосон санхүүжилтийг төрийн эзэмшлийн ногдол ашигт тооцож, шилжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасан байна.

Тус компанид хэрэгжиж буй төслүүдийн ажлын явц, гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төсөл 9.7 хувь, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл 98.7 хувь, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох холболтын төмөр замын төсөл 97.0 хувь, Тавантолгой нүүрс ачих логистикийн төв төсөл 100.0 хувь, Богдхан төмөр замын төсөл 1.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

УИХ-ын 2023 оны 68 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 310 дугаар тогтоолоор “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхийг Зам, тээврийн сайд, “Эрдэнэс тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-д даалгасан байна. УИХ-аас 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон баталж, 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна.

Тайлант онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн төмөр замын дээд, доод бүтэц, гүүр хоолой, хиймэл байгууламж, дохиолол холбоо, зөрлөгүүдийн зам, барилга байгууламж зэрэг 6 багцын 2,822,442.1 сая төгрөгийн хөрөнгийг балансад бүртгэсэн байна. Тус төслийн 5 дугаар багц, 6 дугаар багцаас 9.4 сая ам.доллар, нэмэлт ажил болох шилжүүлэн ачих терминалын төслийн хөрөнгө 30.0 сая ам.доллар, бусад нэмэлт хөрөнгө 2.2 сая ам.долларын хөрөнгийг хүлээн авч, бүртгэлд тусгах ажил хүлээгдэж байна.

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох холболтын төмөр замын төслийн хөрөнгийг балансад бүртгэж аваагүй, 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр улсын комисс хүлээн авч, ашиглалтад шилжсэн байна. Тус төслийн 5 дугаар багц буюу сэлгээний зүтгүүр 2026 оны 04 дүгээр сарын 30-нд нийлүүлэгдэхээр хүлээгдэж байна.

Тавантолгой нүүрс ачилт логистикийн төв төсөл бүрэн хэрэгжиж дууссан тул Зам, тээврийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/311 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг гэрээ дүгнэх ажлыг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар

хангах, ерөнхий гүйцэтгэгч, захиалагч нартай холбоотой санхүүжилтийн асуудлыг эцэслэн шийдвэрлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 206 дугаар тогтоолоор Богдхан төмөр замын төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийг “Эрдэнэс тавантолгой” ХК-д даалгаж, тус оны 230 дугаар тогтоолоор суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгосон байна. Богдхан төмөр замын төсөл нь Рашаант өртөөнөөс Богдхан Уулын урдуур тойрч, Мааньт өртөөтэй холбогдох бөгөөд Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумд, Улаанбаатар хотын Багахангай, Хан-Уул, Сонгинохайран дүүргийн газар нутгийг дамжин, нийт 135.8 км үргэлжлэх, 6 зөрлөг, 3 өртөө, 1,520 мм өргөн царигтай, 16.6 км урттай хоёр туннелтэй баригдахаар төлөвлөгдсөн байна.

Тус төслийг 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс эхлүүлж, Зам, тээврийн хөгжлийн сайдын /хуучнаар/ 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 22 дугаар шуурхай хуралдаанаар төсөлтэй холбоотой бүх гэрээг түдгэлзүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 62 дугаар тэмдэглэлээр “Улаанбаатар төмөр зам” ХНН-ээр хариуцуулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн байна. Дээрх шийдвэртэй холбогдуулан Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл”-ийн гэрчилгээ олгосон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Монгол-Хятадын төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай 68 дугаар тогтоол батлагдсан. Зам, тээврийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ний өдрийн А/01 тушаалаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын төсөвт өртгийг бууруулах зорилгоор ажил гүйцэтгэж байсан нөөц, туршлагатай 3-аас доошгүй БНХАУ-ын төрийн өмчит компаниудын үнийн саналыг харьцуулан судлахыг даалгасан байна.

Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хооронд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай” хэлэлцээрийг байгуулсны дагуу Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр “Мега төслүүдийг эрчимжүүлж, бүтээн байгуулалтыг дэмжих тухай” албан даалгавраар хил холболтын төслийн 2026 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэхийг үүрэг болгосон байна.

“Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын “Чайна энерги ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” ХХК нарын хооронд 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих тухай” хэлэлцээр байгуулагджээ.

Төрийн худалдан авах ажиллагааны даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/1/1752 дугаар бичгээр “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл”-ийг “Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп” ХХК-д хүргүүлж, 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр барилгын ажил гүйцэтгэх гэрээг “Тавантолгой төмөр зам” ХХК-тай, 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр “Эрдэнэс тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК нартай 3 талт санхүүжилтийн гэрээг тус тус байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг “Монголын төмөр зам” ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авах, тус төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцоо нийлж, үндсэн хөрөнгөд бүртгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг даалгасан байна. Тогтоолын хэрэгжилтийг хангах

зорилгоор Зам, тээврийн сайд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/75, А/18 хамтарсан тушаалаар ажлын хэсгийг томилж, түрээсийн гэрээ байгуулах, чиг үүрэг, орон тоог шилжүүлэх, хөрөнгө бүртгэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгүүдийг байгуулсан байна.

“Тавантолгой төмөр зам” ХХК болон “Монголын төмөр зам” ТӨХК нар 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн ТҮГ/2025/11, ТҮГ-2025/07 дугаартай 1,400.0 сая төгрөгийн түрээсийн төлбөр бүхий “Хөрөнгө түрээслэх гэрээ”-г байгуулж, ТӨБЗГ-аас баталсан байна. Тус гэрээний 3 дугаар хавсралтаар “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн өөрийн хөрөнгөөр олж авсан 240,158.4 сая төгрөгийн хөрөнгө, төслийн хүрээнд бий болсон 2,795,745.4 сая төгрөгийн 5 багц хөрөнгийг түрээслэхээр шилжүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан, тус хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж заажээ.

Тус хууль 2025 оны 01 дүгээс сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөн эхэлснээс хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Энэ хуулийн 14.1.2, 14.1.4-т заасан тусгай зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд давхардуулан олгохыг хориглоно” гэж заасны дагуу төмөр замын суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд давхардуулан олгохгүй байхаар хуульчилсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр зам барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхийг даалгасан байна. Тайлант онд “Тавантолгой төмөр зам” ХХК нь “Монголын төмөр зам” ТӨХК-д 78,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслүүдийн гэрээг дүгнэх, өр, авлагыг барагдуулахтай холбоотой дараах асуудлууд гүйцэтгэгч болон захиалагч компанийн удирдлагуудын түвшинд хэлэлцэгдэж байна. Тухайлбал:

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн цогцолбор төмөр замын төсөл хэрэгжих үеийн аж ахуйн зардал болох 6,837.9 сая төгрөгийг ерөнхий гүйцэтгэгчээс нэхэмжилсэн бөгөөд захиалагчаас тус зардлыг хүлээн зөвшөөрөөгүй байна.
- Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох холболтын төмөр замын төслийг хэрэгжүүлэх явцад “Цэций” салхин цахилгаан станц сул зогсолтын зардлыг магадалшгүй ажлын нөөц хөрөнгөөс зарцуулах талаар харилцан зөвшилцөөгүй байна. Мөн ерөнхий гүйцэтгэгчээс IPC-0015-ийн гүйцэтгэлийн төлбөр, суутган барих дүнг захиалагч хугацаанд нь төлөөгүй тул 857.6 сая төгрөгийн алдангийг тооцсон байна. Захиалагчийн зүгээс сэлгээний зүтгүүр Мастер төлөвлөгөөнд тусгагдсан хугацаандаа нийлүүлэгдээгүйгээс 2023 оны 10 дугаар сарын 16-ний өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэлх 903.8 сая төгрөгийн алдангийг тооцсон байна.
- Богдхан төмөр замын төслийн туннел, эстакадан гүүрийн ажилтай холбоотой ерөнхий гүйцэтгэгчээс нийт 14.4 сая ам.долларын зардлыг нэхэмжилсэн байна. Тус зардалд судалгаа, зураг төслийн ажил 5.5 сая ам.доллар, менежментийн зардал 5.2 сая ам.доллар, үйл ажиллагааны бусад зардал 0.6 сая ам.доллар, ерөнхий гүйцэтгэгчийн ашиг 1.7 сая ам.доллар, нэмэгдсэн өртгийн албан татвар 1.3 сая ам.доллар багтсан байна. Төслийн нарийвчилсан зураг төсөлтэй холбоотой 2 гэрээг дүгнэх асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байгаа бөгөөд барилга газар шорооны ажлын гүйцэтгэлтэй холбоотой 4 аж ахуйн нэгжээс авах 605.5 сая төгрөгийн авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх, гүйцэтгэлийн өглөгтэй байгаа 11 байгууллагын үлдэгдэл төлбөрийг байгаль орчны нөхөн сэргээлтийг ажлыг гүйцэтгэсний дараа олгохоор харилцан тохиролцсон байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус компанийн хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын алба өмнөх оны аудитын шийдвэрийн биелэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, А, Б тушаалын хэрэгжилт, цалин хөлс, цаг ашиглалт, албан томилолтын зардал, хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд дотоод аудит хийсэн ба холбогдох зөвлөмжийг хариуцсан нэгжүүдийн удирдах албан тушаалтнуудад хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Тайлант онд тус компанийн гүйцэтгэх удирдлага хоёр удаа солигдсоноос гадна Засгийн газрын шийдвэрээр чиг үүргийг шилжүүлсэн нь нэгж, бүтцийн үйл ажиллагааг доголдоход хүргэсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2025 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн А/100 дугаар тушаалаар баталсан байна. Бодлогын баримт бичгийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүртгэлийн үйл ажиллагаандаа тасралтгүй, тогтвортой мөрдөж ажиллахаар тусгасан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 260,299.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	39,434,750,644.07	8,803,859,143.42	(30,630,891,500.65)
Авлага	224,319,466,420.80	302,293,604,553.11	77,974,138,132.31
Урьдчилгаа	1,515,035,254,968.33	176,170,848,763.99	(1,338,864,406,204.34)
Бараа материал	4,196,585,662.62	6,617,859,435.73	2,421,273,773.11
Бусад санхүүгийн хөрөнгө	73,925,649,809.06	91,584,283,529.96	17,658,633,720.90
Үндсэн хөрөнгө	2,664,717,345,283.33	4,196,458,420,256.23	1,531,741,074,972.90
Нийт хөрөнгө	4,521,629,052,788.21	4,781,928,875,682.44	260,299,822,894.23
Өр төлбөр	498,171,148,476.29	818,291,880,283.79	320,120,731,807.50
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,023,457,904,311.92	3,963,636,995,398.65	(59,820,908,913.27)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,521,629,052,788.21	4,781,928,875,682.44	260,299,822,894.23

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, ашиг, алдагдлын дансдууд байна.

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 8,803.8 сая төгрөг болж, 30,630.9 сая төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 103 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг “Монголын төмөр зам” ТӨХК-д түрээсийн гэрээгээр шилжүүлснээс өөрийн орлого буурсантай холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 302,293.6 сая төгрөг болж, 77,974.1 сая төгрөгөөр өссөн нь Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр зам барих төслийн санхүүжилтийг арилжааны банканд байрших хадгаламжийг барьцаалсан 78,000.0 сая төгрөгийн зээл авч “Монголын төмөр зам” ТӨХК-иас авах авлагаар тайлагнасан нь нөлөөлсөн байна.
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 176,170.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,338,864.4 сая төгрөгөөр буурсан нь урьдчилгаа дансанд хуримтлуулан бүртгэсэн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн 1,340,864.2 сая төгрөг, Тавантолгой нүүрс ачилт логистикийн төв төслийн 16,123.8 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн данс руу хааж бүртгэсэн нь нөлөөлсөн байна.
- Бусад санхүүгийн хөрөнгийн үлдэгдэл 91,584.3 сая төгрөг болж, өмнөх оноос 17,658.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь арилжааны банканд байршиж байгаа хадгаламжийн үлдэгдэл Капитрон банк 34,832.1 сая төгрөг, Төрийн банк 25,000.0 сая төгрөг, Хаан банк 1,860.0 сая төгрөг, Ариг банк 6,000.0 сая төгрөг, Голомт банк 23,892.1 сая төгрөг болж тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 4,196,458.4 сая төгрөг болж, өмнөх оноос 1,531,741.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төмөр замын төслийн урьдчилгаа данснаас шилжүүлэн бүртгэсэн барилга байгууламж 2,021,273.2 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 383,128.4 сая, тээврийн хэрэгсэлд 15 зүтгүүр, 1 суудлын вагон, 510 ачааны вагон нийт 473,059.6 сая төгрөг, тавилга эд хогшил 40.6 сая төгрөг, компьютер бусад хэрэгсэл 259.3 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 259.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 818,291.9 сая төгрөг болж, өмнөх оноос 320,120.7 сая төгрөг болж нэмэгдсэн нь арилжааны банканд байрших хадгаламжийг барьцаалсан зээл 78,000.0 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөр 8,865.1 сая төгрөг, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн 30 хувийн санхүүжилт 254,657.9 сая төгрөгийг “Эрдэнэс тавантолгой” ХК-д өгөх өглөгөөр тайлагнасан нь нөлөөлсөн байна.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 3,963,636.9 сая төгрөг болж, өмнөх оноос 59,820.9 сая төгрөгөөр буурсан нь эздийн өмчийн бусад хэсэгт Өмнөговь аймгийн төмөр замын дагуу газрын 2,129.8 сая төгрөгөөр үнэлж нэмэгдүүлж бүртгэж, тайлант онд 61,950.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласантай холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу хөрөнгө оруулалт болон зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталж, 2025 оны 09 дүгээр сарын 16-ний өдрийн 15 дугаар тогтоолоор тодотгосон байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 103 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн “Монголын төмөр зам” ТӨХК-д шилжүүлж, Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төслийг эрчимжүүлэн, бүтээн байгуулалт эхэлсэн нь тодотгол хийх гол хүчин зүйл болжээ.

Тайлант оны нийт орлогыг 294,259.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 106,580.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 268,547.3 сая төгрөгөөр төлөвлөж, 73,085.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тооцсон байна.

Гүйцэтгэлээр 295,307.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийт урсгал зардалд 102,392.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 246,515.7 сая төгрөгийн зардал гарган, орлогын албан татварын зардал 119.5 сая төгрөг төлж, 61,950.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын төлөвлөгөөний биелэлт 102.6 хувьтай байгаа нь түрээсийн орлогыг төлөвлөснөөс 137 хувийн гүйцэтгэлтэй буюу 5,171.7 сая төгрөгөөр давж биелснээс шалтгаалсан байна. Нийт үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 102,392.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 10,294.2 сая төгрөг буюу 9.1 хувиар дутуу зарцуулалттай байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 9 төсөл арга хэмжээг 268,547.3 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тодотгон баталсан байна. Гүйцэтгэлээр программ хангамжид 202.6 сая төгрөг, тоног төхөөрөмжид 58.1 сая төгрөг, тавилга эд хогшилд 41.3 сая төгрөг, багаж хэрэгсэлд 196.8 сая төгрөг, машин механизм, хөдлөх бүрэлдэхүүнд 377.3 сая төгрөг, камержуулалтын ажилд 81.6 сая төгрөг, хил холболтын төслийн барилга, их засвар болон бусад зардалд 245,558.0 сая төгрөг, нийт 246,515.8 сая төгрөгийг зарцуулж, 92 хувьтай тайлагнасан байна.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 07-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 52 төсөл арга хэмжээг 36,576.3 сая төгрөг, урсгал зардлаар хэрэгжүүлэх 257 төсөл арга хэмжээг 51,885.8 сая төгрөг, нийт 309 төсөл арга хэмжээг 88,462.1 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн байна.

Тайлант онд 47 байгууллагаас бараа, ажил, үйлчилгээг худалдан авч, 2,015.2 сая төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 2 хувьтай тайлагнасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Тавантолгой төмөр зам” ХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Энэхүү тайланд аудит хийсэн байгууллагад хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Лхагвацэнд, аудитор С.Билгүтэй нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/162 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 127,534.3 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 637.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.3.1 Компанийн ТУЗ-ийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ний өдрийн 16 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 09 дүгээр сарын 22-ний өдрийн А/106 дугаар тушаалаар компанийн бүтэц орон тоог 108 байхаар шинэчлэн баталсан боловч батлагдсан орон тоог 21-ээр хэтрүүлж, хөлсөөр ажиллах гэрээт ажиллагсдыг ажиллуулж, 118.5 сая төгрөгийн цалин хөлсийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", 15.2.6-т "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын 1.4.4-т "гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ шинээр байгуулахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн хэрэгжүүлж буй төслийн үр нөлөөтэй уялдуулан чиг үүргийн давхардлын шинжилгээг хийж, бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

4.3.2 Зам, тээврийн яамны салбарын спорт арга хэмжээнд зориулж тушаал гаргаж, төсөв батлаагүй, гүйцэтгэлээр мандат, хулдаасан хэвлэл, хувцас зэрэгт нийт 59.9 сая төгрөг зарцуулж архивлан хэмнэлтгүй, үргүй зардал гаргасан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-т “сахилга баттай байх”, 15 дугаар зүйлийн 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөөгүй, арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

4.3.3 Компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан бөгөөд зохион байгуулалтын нэгжүүд хагас жилээр биелэлтээ тайлагнаагүй, сарын үр дүнгийн нэмэгдлийг Гүйцэтгэх захирлын 2024 оны А/18 тушаалаар батлагдсан журмын дагуу сар бүр хурал зохион байгуулж, хурлын тэмдэглэлд үндэслэн олгодог нь ажлын бүтээмжийг алдагдуулах, бичиг хэргийн зардлыг нэмэгдүүлсэн үр дагавартай байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-т "Зохион байгуулалтын нэгж байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж чиг үүргийн дагуу жилээр төлөвлөгөө боловсруулж тухайн оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн дотор төсвийн шууд захирагчаар батлуулан хэрэгжүүлнэ", 3.3-т "Зохион байгуулалтын нэгж 6, 12 дугаар сард төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шууд захирагчид тайлагнана" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Газар, хэлтсийн удирдлагыг мэргэжил арга зүйгээр хангаж, сахилга батыг сайжруулах, тайлагналын процессыг оновчтой болгох, зардлыг хэмнэж, үр ашгийг нэмэгдүүлэх зөвлөмж өгсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар нийт 295.7 сая төгрөгийн 7 зөрчил илэрсэнд 178.4 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 117.3 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг шалгахад 28 төрлийн мэдээллийг байршуулахаас 27 мэдээллийг шилэн дансанд байршуулж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 14 буюу 1,446.5 сая төгрөгийг хугацаа хоцроосон, 2 буюу 225.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, зарлагын мөнгөн гүйлгээнээс 13 буюу 2,137.0 сая төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроосон, 6 буюу 117.3 сая төгрөгийн гүйлгээг байршуулаагүй, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаанаас 1, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс 1, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 7, нийт 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: "Тавантолгой төмөр зам" ХХК нь хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн шийдвэргүйгээр арилжааны банканд захиалагчийн хяналтын орлого, төслийн гүйцэтгэлийн баталгааг байршуулсан 79,639.5 сая төгрөгийн хадгаламжийг барьцаалан салбар төмөр замын төслийн бүтээн байгуулалтыг гүйцэтгэж буй "Монголын төмөр зам" ТӨХК-д 78,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс тээвэр хөгжлийн банканд /9020700031/ байршуулсан хадгаламж барьцаалсан зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг төлж чадаагүйн улмаас барьцааг суутгуулсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16-т "энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал", 76 дугаар зүйлийн 76.1.18-т "энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал", МУЗГ-ын 2025 оны 21 дүгээр тогтоолын 2-т "Салбар зам барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх..... даалгасугай", ТУЗ-ийн 2025 оны 21-ний өдрийн "Компанийн дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5.1-т "Компанийн үйл ажиллагааны зориулалтаар зээл авах, баталгаа, батлан даалт гаргах эсэх асуудлыг шийдвэрлэх", 8 дугаар зүйлийн 8.4.2-т "Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хянаж, батлах, тайланг дүгнэх" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Компанийн засаглал, санхүүгийн удирдлагатай холбоотой шийдвэр гаргалтыг хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, зөвшөөрөл авч байх, эрсдэлийн үнэлгээ, мөнгөн урсгалын чадавхыг бодитой тооцоолж санхүүгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, дотоод хяналтыг сайжруулах, барьцаанд суутгагдсан хөрөнгийг эргэн төлүүлэхтэй холбоотой хохирлыг барагдуулах арга хэмжээ авах зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт: "Тавантолгой төмөр зам" ХХК нь 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр "Монголын төмөр зам" ХХК-тай хөрөнгө түрээслэх Түг-2025/11, Түг-2025/07 дугаартай гэрээг байгуулж, төслийн 5 багц 2,795,745.4 сая төгрөг, өөрийн хөрөнгө 240,158.3 сая төгрөгийн, нийт 3,035,903.7 сая төгрөгийг хөрөнгийг түрээсээр ашиглуулахдаа ТУЗ-өөс их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл аваагүй, компанийн эрх ашгийг харгалзан үзэлгүй хөрөнгийн элэгдлийн зардлаас доогуур дүнгээр буюу 1,400.0 сая төгрөгөөр түрээсийн төлбөрийг тогтоосноор компанийн ашигт ажиллагаа алдагдсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.3-т "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", 87 дугаар зүйлийн 87.1.1-т "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;", 87.2-т "Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу тогтооно" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Компанийн өмч хөрөнгөтэй холбоотой аливаа шийдвэрийг хөрөнгийн бодит үнэ цэнэ, элэгдэл, ашиглалтын зардал, зах зээлийн жишиг үнэд үндэслэн эдийн засгийн хувьд үр ашигтай байдлаар компанийн эрх ашигт нийцүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлж байх зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт: "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2025 оны үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөг зохих үндэслэл, хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулаагүй, төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж, батлуулаагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13-т "төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах", 83 дугаар зүйлийн 83.1-д "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан

гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1-д "Компанийн урт, дунд, хугацааны стратеги төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих", 8.4.2-т "Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хянаж батлах, тайланг дүгнэх" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн: Бизнес төлөвлөгөөг стратегийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүү, эрсдэлийн удирдлагатай уялдуулан төлөвлөж, батлуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон компанийн засаглал, санхүүгийн удирдлагатай холбоотой зөрчлүүд нь Компанийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 21 дүгээр тогтоолтой нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж авснаар эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 14.4 сая төгрөгийн төлбөрийн акт бүрэн төлөгдөж, 74,236.8 сая төгрөгийн 10 албан шаардлагаас 2 албан шаардлага хэрэгжээгүй, 1 албан шаардлага хэрэгжих шатанд, 2,794.1 сая төгрөгийн 9 зөвлөмжөөс 3 зөвлөмж биелэгдээгүй, 4 зөвлөмж хэрэгжих шатанд байна. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлт 79.4 хувьтай байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	14,439,000.00	1	14,439,000.00	100.0
Албан шаардлага	10	74,236,765,139.22	8	71,534,628,444.59	96.4
Зөвлөмж	9	2,794,124,204.64	6	1,171,030,421.18	41.9
Нийт дүн	20	77,045,328,343.86	15	72,720,097,865.77	79.4

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Өмнөх оны залруулаагүй нэмэгдсэн өртгийн албан татварын хасалтыг зохих хууль, журмын дагуу тооцож, тохирох хөрөнгийн дүнгээс хасалтыг тооцож авлага үүсгэж бүртгэх талаар төслийн хөрөнгийг бүрэн бүртгэж дууссаны дараа Татварын байгууллагаар шалгуулж, үлдэгдлийг тохируулах;
- Эргэдэг авто угсраа бүхий ачааны вагон угсрах сэлбэг нийлүүлэх тендерт шалгарсан хуулийн этгээдтэй 391.8 сая төгрөгийн гэрээг 2024.12.26-ний өдөр байгуулж, сэлбэг нийлүүлж, угсарч суурилуулж 2025.04.25-ний өдөр хүлээн авсан байна. Техник ашиглалтын холбогдох бичиг баримтгүй гэсэн шалтгаанаар тайлант онд ашиглаагүй, вагон угсарсан ажилчдын цалин хөлсийг өртөгт оруулж тооцоогүй, бодит өртгийг үнэн зөв тооцоолоогүй;
- Ерөнхий гүйцэтгэгчээс 18,576.4 сая төгрөгөөр 2 жилийн баталгаат хугацаатай нийлүүлсэн SD70ACe/LW серийн №107 зүтгүүрийг 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр техникийн үзлэг хийж илэрсэн санамжуудыг 9 дүгээр сарын 01-ны дотор засаж хэвийн болгохоор хүлээн авсан боловч тайлант онд доголдлыг арилгаагүй тул гэрээний хэрэгжилтийг хангаж алданги тооцох эсэх;

- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024 оны хурлын тэмдэглэлд 24-95 УНБ улсын дугаартай Тоёота Прадо 150 маркийн автомашин үерийн усанд автсан талаар дурдсан бөгөөд засварын ажлын зардлыг буруутай этгээдээр барагдуулсан эсэх;
- Компанийн гүйцэтгэх удирдлагаас 2024 оны 1/2616, 2025 оны 01/557, 01/1760 тоот бичгээр олон улсын аудитын үйлчилгээ үзүүлэх хөндлөнгийн аудитын үйлчилгээний тайланг хэлэлцүүлж, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороогоор дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүргүүлсэн боловч ТУЗ-өөс хэлэлцүүлэх асуудлын материалыг шаардлага хангахуйц бэлтгээгүй үндэслэлээр тайланг хэлэлцээгүй асуудал;
- Толгой компанитай 2023 онд байгуулсан гэрээний дагуу хүлээн авах вагон пүүний орлого 475.4 сая төгрөгийг хүлээн зөвшөөрч бүртгэх, орлогыг бүрэн төвлөрүүлээгүй асуудал;
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нэр бүхий хоёр байгууллагаас авах 1,222.0 сая төгрөг, 2025 оны тайланд онд нэмэгдсэн 1,165.8 сая төгрөг, нийт 2,387.8 сая төгрөгийн алдангийг тооцоо нийлж баталгаажуулах, санхүүгийн тайланд тусгах асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,695.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2,695.2 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:

Залруулсан алдаа:

- Автомашины сэлбэг хэрэгслийг шаардах хуудсаар албан хэрэгцээнд тавьж олгохдоо тоо ширхэг 8, нийт өртгийг 0.8 сая төгрөгөөр илүү зарлагадаж зөрүү үүссэн;
- Нөөц сэлбэг нэршлээр 865.6 сая төгрөг, бусад нэршлээр 30.7 сая төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэж, 30.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан;
- Борлуулалт болон бусад орлогуудын тооцоог татварын цахим И баримтуудтай тулгахад орлогыг 1,467.8 сая төгрөг, НӨАТ-ыг 146.8 сая төгрөгөөр татварын тайланд илүү илэрхийлсэн;
- Ажилтнуудын 2025 оны 1-6 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан цалингийн дүн нь ХХОАТ-ын тайлангийн дүнгээс 20.5 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 19.3 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан, нийгмийн даатгалын тайлан дахь цалингийн дүн нь татварын тайлангийн цалингийн дүнгээс 81.2 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Урьдчилгаа дансанд 2024 онд олгосон цалингийн урьдчилгаа 24.6 сая төгрөгөөр илүү бүртгэн санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасантай нийцээгүй, “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 161,594.0 сая төгрөгийн 13 зөрчил² илэрсэнд, 8.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 161,366.6 сая төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 218.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар илэрсэн 161,594.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 637.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 160,956.4 сая төгрөгөөр давсан тул “Сөрөг дүгнэлт” өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Завсрын аудитаар төслийн талбайд байрлах агуулахын үлдэгдэлд түүврийн хяналтын тооллого хийхэд 18 кг-ийн 9 ширхэг будаг 0.9 сая төгрөг, 150-тай таслагчийн ир 500 ширхэг 1.6 сая төгрөг, электрод 180 ширхэг 4.5 сая төгрөг, 50 кг-ийн савлагаатай цемент 72 шуудай 1.5 сая төгрөг, нийт 8.6 сая төгрөгийн бараа материал дутсан зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хяналтын тооллогоор дутсан 8.6 сая төгрөгийн бараа материалыг буруутай албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж, улсын төсөв төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн 6 багцын 2,822,442.1 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авч бүртгэхдээ “Дуусаагүй үйлдвэрлэл” дансанд дээрх хөрөнгөтэй холбоотой 43,659.4 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт шилжүүлэн бүртгээгүй, гүйцэтгэгчээс ирүүлсэн үнийн дүнгээр орлогод авч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "тасралтгүй байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Гүйцэтгэх захирлын 2025 оны А/100 тушаалаар баталсан НБББББ-ийн Хэмжилт хэсэгт "..... барилга байгууламжийг өөрөө барьж бий болгож байгаа бол барилгын гүйцэтгэлийн ажил дуусан үндсэн хөрөнгөд шилжүүлэх хүртэлх хугацаанд тухайн барилгатай холбоотой гарсан бүх зардлыг хуримтлуулан бүртгэснээр дуусаагүй барилгыг хүлээн зөвшөөрнө", "Нэг буюу хэд хэдэн хөрөнгийг мөнгө ба мөнгөн бус хөрөнгийн аль алийг оролцуулан солилцох замаар худалдан авсан үед хөрөнгө тус бүрийн өртгийг тодорхойлон бүртгэнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгоогүй, зардлын гүйцэтгэл, өртгийн тооцооллыг үнэн зөв хийгээгүй хөрөнгийг орлогод авсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.2.2 Санхүүгийн тайланд тусгагдсан авлагаас томоохон харилцагч болох "Бодь Интернэшнл" ХХК-аас авах 82,690.3 сая төгрөг, бусад 48 харилцагч байгууллагуудаас авах 1,237.3 сая төгрөг, нийт 83,927.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, бодитой эсэх нь нотлогдоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг

шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.2.3 Санхүүгийн тайланд тайлагнасан өр төлбөрийн үлдэгдэлд "Бодь Интернэшнл" ХХК-д өгөх 32,352.6 сая төгрөг, бусад 158 харилцагч хувь хүн, байгууллагад өгөх өглөг 699.9 сая төгрөг, нийт 33,052.4 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.2.4 Хөдөлмөрийн дотоод журмыг баримтлалгүй хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээтэй ажилчдад 144.6 сая төгрөгийн сарын үр дүнгийн нэмэгдэл, туршилтаар ажиллаж байсан хугацаатай хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд 0.2 сая төгрөг, тэтгэвэр тогтоолгосон ажилтанд 0.9 сая төгрөгийн ажилласан жилийн нэмэгдлийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-т "Ажилтны үр чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно", Гүйцэтгэх захирлын 2024 оны А/18 тушаалаар батлагдсан "Сарын үр дүнгийн нэмэгдэл олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4-т "Дараах тохиолдолд ажилтанд сарын ажлын үр дүнгийн нэмэгдлийг олгохгүй. Үүнд:" 3.4.1-т "Ажил гүйцэтгэх гэрээгээр болон түр ажлын /хөлсөөр ажиллах/ байрны гэрээтэй ажиллаж байгаа ажилтанд олгохгүй", 2023 оны А/65 тушаалаар батлагдсан "Ажилласан жилийн нэмэгдэл олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2-т "Ажилтанд хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн өдрөөс эхлэн ажилласан жилийн нэмэгдэл олгож эхлэх бөгөөд туршилтын хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаанд ажилласан жилийн нэмэгдлийг олгохгүй", 2023 оны А/28 тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1.11-т "Хуулийн дагуу өндөр настны тэтгэвэр тогтоолгосон ажилтанд удаан жилийн нэмэгдэл олгохгүй" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн дотоод журмаар холбогдох хууль тогтоомжид заасан хэм хэмжээнээс давсан зохицуулалт тогтоосон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.2.5 Завсрын аудитаар бараа материалын дансны үлдэгдэлд түүвэр тулгалт хийж, биет тест хэрэгжүүлэхэд төмөр замын өртөө, байгууламжийн бүсэд хашаа барьж байгуулах зорилгоор худалдан авсан нийт 168.4 сая төгрөгийн төмөр шон, савх төмөр, дай төмөр гэх мэт хашаа барьж байгуулах материалыг зориулалтын дагуу ашиглаагүй, гадаа талбайд ил задгай байршуулсан, дахин ашиглах боломжгүй болох, үрэгдэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", 73 дугаар зүйлийн 73.4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан

хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, дээрх хөрөнгүүдийг үр ашигтай байдлаар шийдвэрлэх албан шаардлага хүргүүлсэн.

5.2.6 Төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахаас зайлсхийж, нийт 111.9 сая төгрөгийг төсөвт өртөг бүхий ажлыг хорин сая төгрөгөөс доош үнийн дүнтэйгээр хэсэгчлэн хуваан, шууд гэрээ байгуулах аргаар албан тасалгааны засварын ажлыг гүйцэтгүүлсэн байна. Ижил төстэй шинж чанартай хэвлэл, танилцуулга, контент боловсруулах ажилд 101.2 сая төгрөг, сургалтын зардалд 105.3 сая төгрөг, өвс тэжээлийн худалдан авалтад 20.0 төгрөг, нийт 338.5 сая төгрөгийг зарцуулахдаа үнийн санал ирүүлсэн байгууллагуудыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.2.7 Тайлант онд ажил олгогчоос хөдөлмөрийн харилцааг цуцалсны тэтгэмжийг 8 хүнд олгохдоо 33.8 сая төгрөг, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 4 ажилтанд 40.6 сая төгрөг, нийт 74.4 сая төгрөгийг нэмэгдүүлэн олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-т "Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно:", 82.1.1-т "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад зургаан сараас хоёр жил хүртэл ажилласан бол нэг ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.2-т "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хоёр жилээс тав хүртэл жил ажилласан бол хоёр ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.3-т "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасан тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.2.8 Өмнөх оны аудитаар өгсөн 337.1 сая төгрөгийн ашиглах боломжгүй болсон, гэмтэж хоцрогдолд орсон бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолж, хөрөнгийн чанар байдлыг тодорхойлон, өртгийг бодитой тогтоож бүртгэл тусгах талаар төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэр гаргуулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн

тогтоох”, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Ашиглах боломжгүй, гэмтэж хоцрогдолд орсон бараа материалын өртгийг бодитой тогтоогоогүй, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлдэггүй зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

5.2.9 Өмнөх оны аудитаар өгсөн 810.5 сая төгрөгийн насжилт өндөртэй авлагад үнэ цэнийн бууралт тооцож, бодит үнэ цэнээр бүртгэх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Насжилт өндөртэй авлагыг ангилах, барагдуулах, бодит үнэ цэнийг тооцох талаар арга хэмжээ авч ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөөгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон актыг байгууллагаас төлж буруутай албан тушаалтнаас авлагаар бүртгэсэн боловч барагдуулаагүй, нэр зөрүүтэй үүсгэсэн 69.2 сая төгрөгийн авлага байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т “Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэнтэй тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтад үндэслэн нэр зөрүүтэй үүсгэсэн авлагыг залруулах, авлагыг барагдуулах арга хэмжээ авах, авлагын бодит үнэ цэнийн бууралтыг тооцож ажиллах.

5.3.2 Богдхан төмөр зам төсөлтэй холбоотой “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд 21,132.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, туслан гүйцэтгэгч компаниудад өгөх 547.3 сая төгрөгийн өглөгтэй, цаашид төслийн хөрөнгийг бүртгэх, ашиглах эсэхийг эцэслэн шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2-т "санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх", 10 дугаар зүйлийн 10.1.6-т "бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинд үндэслэн үйл ажиллагаа, бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох", Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна", УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 8.1.2-т "стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр зам, авто замуудыг барьж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зам, тээврийн дэд бүтцийг өргөжүүлнэ", 5 дугаар хавсралтаар батлагдсан "2.4.Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын 27 дахь зүйл "Богдхан төмөр зам төсөл", МУЗГ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" баримт бичгийн 3.6 дугаар зүйлийн 3.6.1.3-т "Богдхан төмөр зам болон баруун босоо чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийг хийж дуусгана", 6 6.1 дүгээр зүйлийн 6.1.12-т "Богдхан төмөр замын төслийг түшиглэн "Хөгжлийн алтан тойрог" байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Компанийн балансад бүртгэлтэй дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлуулан бүртгэсэн зардлын бодит гүйцэтгэлийг тогтоож, төслийн үр ашиг, эдийн засгийн өгөөжийг харгалзан цаашид хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлүүлэх.

5.3.3 МУЗГ-ын 2025 оны 103 дугаар тогтоолын дагуу "Монголын төмөр зам" ХХК-тай хөрөнгө түрээслэх Түг-2025/11, Түг-2025/07 дугаартай гэрээг байгуулж, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн тээвэр, суурь бүтцийн үйл ажиллагааг шилжүүлсэн байна. Тээвэр, суурь бүтцийн үйл ажиллагаатай хамааралтай 1,979.5 сая төгрөгийн бараа материал байгаагаас 149.6 сая төгрөгийн дугуй, резинэн жийрэг зэрэг материалууд нь хадгалалтын хугацаа дуусах, дахин ашиглах боломжгүй болох эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэсэнтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ашиглалт хамгаалалтад хяналт тавьж, төслийн хөрөнгийг эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байлгах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
						Залруулсан		Залруулагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Автомашин сэлбэг хэрэгслийг шаардах хуудсаар албан хэрэгцээнд тавьж олгохдоо тоо ширхэг 8, нийт өртгийг 0.8 сая төгрөгөөр илүү зарлагдаж зөрүү үүссэн.	1	0.8	1	0.8	1	0.8		
2	Нөөц сэлбэг нэршлээр 865.6 сая төгрөг, бусад нэршлээр 30.7 сая төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэж, 30.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан.	1	926.6	1	926.6	1	926.6		
3	Борлуулалт болон бусад орлогуудын тооцоог татварын цахим И баримтуудтай тулгахад орлогыг 1,467.8 сая төгрөг, НӨАТ-ыг 146.8 сая төгрөгөөр татварын тайланд илүү илэрхийлсэн.	1	1,614.6	1	1,614.6	1	1,614.6		
4	Ажилтнуудын 2025 оны 1-6 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан цалингийн дүн нь ХХОАТ-ын тайлангийн дүнгээс 20.5 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 19.3 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан, нийгмийн даатгалын тайлан дахь цалингийн дүн нь татварын тайлангийн цалингийн дүнгээс 81.2 сая төгрөгөөр зөрүүтэй	1	128.7	1	128.7	1	128.7		
5	Урьдчилгаа дансанд 2024 онд олгосон цалингийн урьдчилгаа 24.6 сая төгрөгөөр илүү бүртгэн санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн.	1	24.6	1	24.6	1	24.6		
	Дүн	5	2,695.2	5	2,695.2	5	2,695.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Завсрын аудитаар төслийн талбайд байрлах агуулахын үлдэгдэлд түүврийн хяналтын тооллого хийхэд 18 кг-ийн 9 ширхэг будаг 0.9 сая төгрөг, 150-тай таслагчийн ир 500 ширхэг 1.6 сая төгрөг, электрод 180 ширхэг 4.5 сая төгрөг, 50 кг-ийн савлагаатай цемент 72 шуудай 1.5 сая төгрөг, нийт 8.6 сая төгрөгийн бараа материал дутсан зөрчил илэрсэн.	1	8.6	1	8.6				
2	Тайлант онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн 6 багцын 2,822,442.1 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авч бүртгэхдээ “Дуусаагүй үйлдвэрлэл” дансанд дээрх хөрөнгөтэй холбоотой 43,659.4 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт шилжүүлэн бүртгээгүй, гүйцэтгэгчээс ирүүлсэн үнийн дүнгээр орлогод авч бүртгэсэн байна.	1	43,659.4			1	43,659.4		
3	Санхүүгийн тайланд тусгагдсан авлагаас томоохон харилцагч болох “Бодь Интернэшнл” ХХК-аас авах 82,690.3 сая төгрөг, бусад 48 харилцагч байгууллагуудаас авах 1,237.3 сая төгрөг, нийт 83,927.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, бодитой эсэх нь нотлогдоогүй байна.	1	83,927.6			1	83,927.6		
4	Санхүүгийн тайланд тайлагнасан өр төлбөрийн үлдэгдэлд “Бодь Интернэшнл” ХХК-д өгөх 32,352.6 сая төгрөг, бусад 158 харилцагч хувь хүн, байгууллагад өгөх өглөг 699.9 сая төгрөг, нийт 33,052.4 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	33,052.4			1	33,052.4		
5	Хөдөлмөрийн дотоод журмыг баримтлалгүй хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээтэй ажилчдад 144.6 сая төгрөгийн сарын үр дүнгийн нэмэгдэл, туршилтаар ажиллаж байсан хугацаатай хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд 0.2 сая төгрөг, тэтгэвэр тогтоолгосон ажилтанд 0.9 сая төгрөгийн ажилласан жилийн нэмэгдлийг олгосон байна.	1	145.8			1	145.8		
6	Завсрын аудитаар бараа материалын дансны үлдэгдэлд түүвэр тулгалт хийж, биет тест хэрэгжүүлэхэд төмөр замын өртөө, байгууламжийн бүсэд хашаа барьж байгуулах зорилгоор худалдан авсан нийт 168.4 сая төгрөгийн төмөр шон, савх төмөр, дай төмөр гэх мэт хашаа барьж байгуулах материалыг зориулалтын дагуу ашиглаагүй, гадаа талбайд ил задгай байршуулсан, дахин ашиглах боломжгүй болох, үрэгдэх эрсдэлтэй байна.	1	168.4			1	168.4		
7	Төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахаас зайлсхийж, нийт 111.9 сая төгрөгийг төсөвт өртөг бүхий ажлыг хорин сая төгрөгөөс доош үнийн дүнтэйгээр хэсэгчлэн хуваан, шууд гэрээ	1	338.5			1	338.5		

	байгуулах аргаар албан тасалгааны засварын ажлыг гүйцэтгүүлсэн байна. Ижил төстэй шинж чанартай хэвлэл, танилцуулга, контент боловсруулах ажилд 101.2 сая төгрөг, сургалтын зардалд 105.3 сая төгрөг, өвс тэжээлийн худалдан авалтад 20.0 төгрөг, нийт 338.5 сая төгрөгийг зарцуулахдаа үнийн санал ирүүлсэн байгууллагуудыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.								
8	Тайлант онд ажил олгогчоос хөдөлмөрийн харилцааг цуцалсны тэтгэмжийг 8 хүнд олгохдоо 33.7 сая төгрөг, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 4 ажилтанд 40.6 сая төгрөг, нийт 74.4 сая төгрөгийг нэмэгдүүлэн олгосон байна.	1	74.4			1	74.4		
9	Өмнөх оны аудитаар өгсөн 337.1 сая төгрөгийн ашиглах боломжгүй болсон, гэмтэж хоцрогдолд орсон бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолж, хөрөнгийн чанар байдлыг тодорхойлон, өртгийг бодитой тогтоож бүртгэл тусгах талаар төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэр гаргуулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-			1	-		
10	Өмнөх оны аудитаар өгсөн 810.5 сая төгрөгийн насжилт өндөртэй авлагад үнэ цэний бууралт тооцож, бодит үнэ цэнээр бүртгэх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-			1	-		
11	Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон актыг байгууллагаас төлж буруутай албан тушаалтнаас авлагаар бүртгэсэн боловч барагдуулаагүй, нэр зөрүүтэй үүсгэсэн 69.2 сая төгрөгийн авлага байна.	1	69.2					1	69.2
12	Богдхан төмөр зам төсөлтэй холбоотой "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд 21,132.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, туслан гүйцэтгэгч компаниудад өгөх 547.3 сая төгрөгийн өглөгтэй, цаашид төслийн хөрөнгийг бүртгэх, ашиглах эсэхийг эцэслэн шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1	-
13	МУЗГ-ын 2025 оны 103 дугаар тогтоолын дагуу "Монголын төмөр зам" ХХК-тай хөрөнгө түрээслэх Түг-2025/11, Түг-2025/07 дугаартай гэрээг байгуулж, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн тээвэр, суурь бүтцийн үйл ажиллагааг шилжүүлсэн байна. Тээвэр, суурь бүтцийн үйл ажиллагаатай хамааралтай 1,979.5 сая төгрөгийн бараа материал байгаагаас 149.6 сая төгрөгийн дугуй, резинэн жийрэг зэрэг материалууд нь хадгалалтын хугацаа дуусах, дахин ашиглах боломжгүй болох эрсдэлтэй байна.	1	149.7					1	149.7
	Дүн	13	161,594.0	1	8.6	9	161,366.5	3	218.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Компанийн ТУЗ-ийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ний өдрийн 16 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 09 дүгээр сарын 22-ний өдрийн А/106 дугаар тушаалаар компанийн бүтэц орон тоог 108 байхаар шинэчлэн баталсан боловч батлагдсан орон тоог 21-ээр хэтрүүлж, хөлсөөр ажиллах гэрээт ажиллагсдыг ажиллуулж, 118.5 сая төгрөгийн цалин хөлсийг олгосон байна.	1	118.5			1	118.5		
Зам, тээврийн яамны салбарын спорт арга хэмжээнд зориулж тушаал гаргасан боловч төсөв батлаагүй, гүйцэтгэлээр мандат, хулдаасан хэвлэл, хувцас зэрэгт нийт 59.9 сая төгрөг зарцуулж арвилан хэмнэлтгүй, үргүй зардал гаргасан байна.	1	59.9			1	59.9		
Компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан бөгөөд зохион байгуулалтын нэгжүүд хагас жилээр биелэлтээ тайлагнаагүй, сарын үр дүнгийн нэмэгдлийг Гүйцэтгэх захирлын 2024 оны А/18 тушаалаар батлагдсан журмын дагуу сар бүр хурал зохион байгуулж, хурлын тэмдэглэлд үндэслэн олгодог нь ажлын бүтээмжийг алдагдуулах, бичиг хэргийн зардлыг нэмэгдүүлсэн үр дагавартай байна.	1	-					1	-
Дүн	3	178.4			2	178.4	1	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 14 буюу 1,446.5 сая төгрөгийг хугацаа хоцроосон, 2 буюу 225.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, зарлагын мөнгөн гүйлгээнээс 13 буюу 2,137.0 сая төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроосон, 6 буюу 117.3 сая төгрөгийн гүйлгээг байршуулаагүй, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаанаас 1, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс 1, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 7, нийт 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	117.3					1	117.3
Дүн	1	117.3					1	117.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
"Тавантолгой төмөр зам" ХХК нь хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн шийдвэргүйгээр арилжааны банкинд захиалагчийн хяналтын орлого, төслийн гүйцэтгэлийн баталгааг байршуулсан 79,639.5 сая төгрөгийн хадгаламжийг барьцаалан салбар төмөр замын төслийн бүтээн байгуулалтыг гүйцэтгэж буй "Монголын төмөр зам" ТӨХК-д 78,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.	1	-					1	-

Үүнээс тээвэр хөгжлийн банкинд /9020700031/ байршуулсан хадгаламж барьцаалсан зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг төлж чадаагүйн улмаас барьцааг суутгуулсан байна.								
“Тавантолгой төмөр зам” ХХК нь 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр “Монголын төмөр зам” ХХК-тай хөрөнгө түрээслэх Түг-2025/11, Түг-2025/07 дугаартай гэрээг байгуулж, төслийн 5 багц 2,795,745.4 сая төгрөг, өөрийн хөрөнгө 240,158.3 сая төгрөгийн, нийт 3,035,903.7 сая төгрөгийг хөрөнгийг түрээсээр ашиглуулахдаа ТУЗ-өөс их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл аваагүй, компанийн эрх ашгийг харгалзан үзэлгүй хөрөнгийн элэгдлийн зардлаас доогуур дүнгээр буюу 1,400.0 сая төгрөгөөр түрээсийн төлбөрийг тогтоосноор компанийн ашигт ажиллагаа алдагдсан байна.	1	-					1	-
“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөг зохих үндэслэл, хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулаагүй, төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж, батлуулаагүй байна.	1	-			1	-		
Дүн	3	-					2	-
Нийт дүн	7	295.7			3	178.4	4	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 183/А0171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/КА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Завсрын аудитаар төслийн талбайд байрлах агуулахын үлдэгдэлд түүврийн хяналтын тооллого хийхэд 18 кг-ийн 9 ширхэг будаг 907,200.00 (есөн зуун долоон мянга хоёр зуун) төгрөг, 150-тай таслагчийн ир 500 ширхэг 1,645,650.00 (нэг сая зургаан зуун дөчин таван мянга зургаан зуун тавин) төгрөг, электрод 180 ширхэг 4,493,998.80 (дөрвөн сая дөрвөн зуун ерэн гурван мянга есөн зуун ерэн найман төгрөг наян мөнгө) төгрөг, 50кг-ийн савлагаатай цемент 72 шуудай 1,512,050.40 (нэг сая таван зуун арван хоёр мянга тавин төгрөг дөчин мөнгө) төгрөг, нийт 8,558,899.20 (найман сая таван зуун тавин найман мянган төгрөг найман зуун ерэн есөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн бараа материал дутсан зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хяналтын тооллогоор дутсан 8,558,899.20 (найман сая таван зуун тавин найман мянган төгрөг найман зуун ерэн есөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн бараа материалыг буруутай албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



Z:\Akt\2026\0316\SAG-34.Docx

1526200245



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 879/АД171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн 6 багцын 2,822,442,113,478.93 (хоёр их наяд найман зуун хорин хоёр тэрбум дөрвөн зуун дөчин хоёр сая нэг зуун арван гурван мянга дөрвөн зуун далан найман төгрөг ерэн гурван мөнгө) төгрөгийн хөрөнгийг орлогод авч бүртгэхдээ “Дуусаагүй үйлдвэрлэл” дансанд дээрх хөрөнгөтэй холбоотой 43,659,350,354.98 (дөчин гурван тэрбум зургаан зуун тавин есөн сая гурван зуун тавин мянга гурван зуун тавин дөрвөн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт шилжүүлэн бүртгээгүй, гүйцэтгэгчээс ирүүлсэн үнийн дүнгээр орлогод авч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” Гүйцэтгэх захирлын 2025 оны А/100 тушаалаар баталсан НБББББ-ийн Хэмжилт хэсэгт “.... барилга байгууламжийг өөрөө барьж бий болгож байгаа бол барилгын гүйцэтгэлийн ажил дуусан үндсэн хөрөнгөд шилжүүлэх хүртэлх хугацаанд тухайн барилгатай холбоотой гарсан бүх зардлыг хуримтлуулан бүртгэснээр дуусаагүй барилгыг хүлээн зөвшөөрнө”, “Нэг буюу хэд хэдэн хөрөнгийг мөнгө ба мөнгөн бус хөрөнгийн аль алийг оролцуулан солилцох замаар худалдан авсан үед хөрөнгө тус бүрийн өртгийг тодорхойлон бүртгэнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-т “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-66.Docx

1526181160

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгоогүй, зардлын гүйцэтгэл, өртгийн тооцооллыг үнэн зөв хийгээгүй хөрөнгийг орлогод авсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 880/А0171328

Улаанбаатар хот

САГ - 2026 / 61 / ИА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгагдсан авлагаас томоохон харилцагч болох "Бодь Интернэшнл" ХХК-аас авах 82,690,273,432.21 (наян хоёр тэрбум зургаан зуун ерэн сая хоёр зуун далан гурван мянга дөрвөн зуун гучин хоёр төгрөг хорин нэгэн мөнгө) төгрөг, бусад 48 харилцагч байгууллагуудаас авах 1,237,317,446.23 (нэг тэрбум хоёр зуун гучин долоон сая гурван зуун арван долоон мянга дөрвөн зуун дөчин зургаан төгрөг хорин гурван мөнгө) төгрөг, нийт 83,927,590,878.44 (наян гурван тэрбум есөн зуун хорин долоон сая таван зуун ерэн мянга найман зуун далан найман төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, бодитой эсэх нь нотлогдоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 881/А0171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тайлагнасан өр төлбөрийн үлдэгдэлд "Бодь Интернэшнл" ХХК-д өгөх 32,352,588,981.17 (гучин хоёр тэрбум гурван зуун тавин хоёр сая таван зуун наян найман мянга есөн зуун наян нэгэн төгрөг арван долоон мөнгө) төгрөг, бусад 158 харилцагч хувь хүн, байгууллагад өгөх өглөг 699,851,032.16 (зургаан зуун ерэн есөн сая найман зуун тавин нэгэн мянга гучин хоёр төгрөг арван зургаан мөнгө) төгрөг, нийт 33,052,440,013.33 (гучин гурван тэрбум тавин хоёр сая дөрвөн зуун дөчин мянга арван гурван төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ
И ЭРДЭНЭЦЭЦЭГ
БЛХАГВАЦЭНД
С БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 882/А0171328

Улаанбаатар хот

САГ -2026/61/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөрийн дотоод журмыг баримтлалгүй хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээтэй ажилчдад 144,618,449.58 (нэг зуун дөчин дөрвөн сая зургаан зуун арван найман мянга дөрвөн зуун дөчин есөн төгрөг тавин найман мөнгө) төгрөгийн сарын үр дүнгийн нэмэгдэл, туршилтаар ажиллаж байсан хугацаатай хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд 242,000.00 (хоёр зуун дөчин хоёр мянган) төгрөг, тэтгэвэр тогтоолгосон ажилтанд 937,300.00 (есөн зуун гучин долоон мянга гурван зуун) төгрөгийн ажилласан жилийн нэмэгдлийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-т "Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно", Гүйцэтгэх захирлын 2024 оны А/18 тушаалаар батлагдсан "Сарын үр дүнгийн нэмэгдэл олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4-т "Дараах тохиолдолд ажилтанд сарын ажлын үр дүнгийн нэмэгдлийг олгохгүй. Үүнд:" 3.4.1-т "Ажил гүйцэтгэх гэрээгээр болон түр ажлын /хөлсөөр ажиллах/ байрны гэрээтэй ажиллаж байгаа ажилтанд олгохгүй", 2023 оны А/65 тушаалаар батлагдсан "Ажилласан жилийн нэмэгдэл олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2-т "Ажилтанд хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн өдрөөс эхлэн ажилласан жилийн нэмэгдэл олгож эхлэх бөгөөд туршилтын хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаанд ажилласан жилийн нэмэгдлийг олгохгүй", 2023 оны А/28 тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1.11-т "Хуулийн дагуу өндөр настны тэтгэвэр тогтоолгосон ажилтанд удаан жилийн нэмэгдэл олгохгүй" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага

өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-т "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хөдөлмөрийн дотоод журмаар холбогдох хууль тогтоомжид заасан хэм хэмжээнээс давсан зохицуулалт тогтоосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 883/А0171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Завсрын аудитаар бараа материалын дансны үлдэгдэлд түүвэр тулгалт хийж, биет тест хэрэгжүүлэхэд төмөр замын өртөө, байгууламжийн бүсэд хашаа барьж байгуулах зорилгоор худалдан авсан нийт 168,446,809.18 (нэг зуун жаран найман сая дөрвөн зуун дөчин зургаан мянга найман зуун есөн төгрөг арван найман мөнгө) төгрөгийн төмөр шон, савх төмөр, дай төмөр гэх мэт хашаа барьж байгуулах материалыг зориулалтын дагуу ашиглаагүй, гадаа талбайд ил задгай байршуулсан, дахин ашиглах боломжгүй болох, үрэгдэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", 73 дугаар зүйлийн 73.4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, дээрх хөрөнгүүдийг үр ашигтай байдлаар шийдвэрлэж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 884/АД171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ний өдрийн 16 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар компанийн бүтэц орон тоог 108 байхаар шинэчлэн баталсан боловч батлагдсан орон тоог 21-ээр хэтрүүлж, хөлсөөр ажиллах гэрээт ажиллагсдыг ажиллуулж, 118,494,729.00 (нэг зуун арван найман сая дөрвөн зуун ерөн дөрвөн мянга долоон зуун хорин есөн төгрөг) төгрөгийн цалин хөлсийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын 1.4.4-т "гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ шинээр байгуулахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Компанийн хэрэгжүүлж буй төслийн үр нөлөөтэй уялдуулан чиг үүргийн давхардлын шинжилгээг хийж, бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Танбаатар) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

ЦНАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ

9206109
ATA16087
9025081411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-66.Docx

1526181172



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 885/А0171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахаас зайлсхийж, нийт 111,900,000.00 (нэг зуун арван нэгэн сая есөн зуун мянган) төгрөгийг төсөвт өртөг бүхий ажлыг хорин сая төгрөгөөс доош үнийн дүнтэйгээр хэсэгчлэн хуваан, шууд гэрээ байгуулах аргаар албан тасалгааны засварын ажлыг гүйцэтгүүлсэн байна. Ижил төстэй шинж чанартай хэвлэл, танилцуулга, контент боловсруулах ажилд 101,200,000.00 (нэг зуун нэг сая хоёр зуун мянган) төгрөг, сургалтын зардалд 105,300,000.00 (нэг зуун таван сая гурван зуун мянган) төгрөг, өвс тэжээлийн худалдан авалтад 20,000,000.00 (хорин сая) төгрөг, нийт 338,505,052.00 (гурван зуун гучин найман сая таван зуун таван мянга жаран хоёр) төгрөгийг зарцуулахдаа үнийн санал ирүүлсэн байгууллагуудыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэсэнтэй нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 886/А0171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зам, тээврийн яамны салбарын спорт арга хэмжээнд оролцох тушаал гаргасан боловч төсөв батлаагүй, гүйцэтгэлээр мандат, хулдаасан хэвлэл, хувцас зэрэгт нийт 59,909,480.00 (тавин есөн сая есөн зуун есөн мянга дөрвөн зуун наян мянган) төгрөг зарцуулж арвилан хэмнэлтгүй, үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-т "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах"-ыг хориглон заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөөгүй, арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий няглан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 887/А0171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөг зохих үндэслэл, хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулаагүй, төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж, батлуулаагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13-т "төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах", 83 дугаар зүйлийн 83.1-д "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1-д "Компанийн урт, дунд, хугацааны стратеги төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих", 8.4.2-т "Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хянаж батлах, тайланг дүгнэх" гэсэнтэй нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Бизнес төлөвлөгөөг стратегийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүү, эрсдэлийн удирдлагатай уялдуулан төлөвлөж, батлуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ

9025109
ATA16087
9025081411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-66.Docx

1526181176



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 888/A0171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/ИА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ажил олгогчоос хөдөлмөрийн харилцааг цуцалсны тэтгэмжийг 8 хүнд олгохдоо 33,769,000.00 (гучин гурван сая долоон зуун жаран есөн мянган) төгрөг, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 4 ажилтанд 40,682,375.50 (дөчин сая зургаан зуун наян хоёр мянга гурван зуун далан таван төгрөг тавин мөнгө) төгрөг, нийт 74,451,375.50 (далан дөрвөн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга гурван зуун далан таван төгрөг тавин мөнгө) төгрөгийг нэмэгдүүлэн олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д "Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно:", 82.1.1-т "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад зургаан сараас хоёр жил хүртэл ажилласан бол нэг ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.2-т "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хоёр жилээс тав хүртэл жил ажилласан бол хоёр ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.3-т "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хуульд заасан тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 101581100, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264030

Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAG-66.Docx

1526181178



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 889/АД171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/КА -СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн 810,546,110.64 (найман зуун арван сая таван зуун дөчин зургаан мянга нэг зуун арван төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн насжилт өндөртэй авлагад үнэ цэнийн бууралт тооцож, бодит үнэ цэнээр бүртгэх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Насжилт өндөртэй авлагыг ангилах, барагдуулах, бодит үнэ цэнийг тооцох, нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөөгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 890/А0171328

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн 337,147,672.82 (гурван зуун гучин долоон сая нэг зуун дөчин долоон мянга зургаан зуун далан хоёр төгрөг наян хоёр мөнгө) төгрөгийн ашиглах боломжгүй болсон, гэмтэж хоцрогдолд орсон бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолж, хөрөнгийн чанар байдлыг тодорхойлон, өртгийг бодитой тогтоож бүртгэл тусгах талаар төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэр гаргуулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ашиглах боломжгүй, гэмтэж хоцрогдолд орсон бараа материалын өртгийг бодитой тогтоогоогүй, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Х.Пүрэвжаргал), ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



ЦИХРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ЛХАГВАЦЭНД
С.БИЛГҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 20-11-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga\2026\0316 SAG-66.Docx

1526181184